



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр, Даваа гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4
<hr/>	
<i>1.Горимын санал</i>	4

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Хянан шалгах түр хороо /Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс  
нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа  
хүндрэлийг шалган тогтоох/-ны 04 дүгээр сарын 03-ны өдөр  
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Хянан шалгах түр хорооны дарга Г.Ганболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 69.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 38 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: С.Одонтуяа;  
Чөлөөтэй: Ц.Анандбазар, Г.Мөнхцэцэг;  
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Наранбаатар.*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Х.Хэрлэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Түр хорооны дарга Г.Ганболд Түр хорооны сонсгол явуулахтай холбоотой гэрчээр дуудах хүмүүсийн нэрсийг тогтоох учраас хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргав.

**Г.Ганболд:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 5  
Бүгд: 9  
44.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Ганболд:** Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4

Бүгд: 9  
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Ганболд:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул 16 цаг 43 минутад хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 5 минут үргэлжилж, 13 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 69.2 хувийн ирцтэйгээр 17 цаг 43 минутад өндөрлөв

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТҮР ХОРООНЫ ДАРГА

Г.ГАНБОЛД

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр,  
Даваа гараг  
Төрийн ордон “Жанжин  
Д.Сүхбаатар” танхим  
09 цаг 30 минут.

### **ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Ганболд:** Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгаж байна. Хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэл бэрхшээлийг шалган тогтоох үүрэг бүхий Түр хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр Буланы Бейсен, Гочоогийн Ганболд, Сайнхүүгийн Ганбаатар, Наянтайн Ганибал, Сандагийн Бямбацогт, Тогмидын Доржханд, Төмөртоогоогийн Энхтүвшин, Лхагвын Мөнхбаатар нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ингээд өнөөдөр хуралдааны дэгийн дагуу Түр хорооны сонсгол явуулахтай холбогдуулаад гэрчээр дуудах хүмүүсийнхээ нэрсийг тогтох байгаа.

Тийм учраас хуралдааныг одоо хаалттай горимоор явуулъя гэсэн горимын санал оруулж байна.

Хуралдааны дэгтэй холбогдуулаад асуулт асуух үг хэлэх гишүүн байна уу?

Байхгүй бол хуралдааныг хаалттай горимоор явуулъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Ганибал гишүүний микрофоныг өгье.

**Н.Ганибал:** Би нөгөө төхөөрөмж ажилласангүй. Дахиж санал хурааж өгнө үү гэж хурал даргалагчаас хүсэж байна.

**Г.Ганболд:** Ганибал гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Ганибал гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг хаалттай горимоор хэлэлцье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хуралд оролцсон гишүүдийн 55.6 хувь нь дэмжсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлъя.

16.43 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА